

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Мөрийн Самдан	Дугаар	1033
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянгол дүүрэг
Төрсөн газар	Дундговь аймгийн Цагаандэлгэр сум	Төрсөн он	1918
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Баруун Чойр	Сүм хийдийн дугаар	ДУЦД 071
Одоогийн сүм хийд	Гандантэгчинлэн хийд	Сүм хийдийн дугаар	УВ 01
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Дундговь аймгийн Цагаандэлгэр сум Баруун Чойрын хийд

Чойрт сууж хурал ном үздэг байлаа. Би 7, 8 настайгаасаа эхлэн суусан. 20-иод жил суусан. Баруун чойр нь Чойр, Цогчэн, Жүд, Манба, Авга, Ламрим, Донир, Дүйнхор, Ёга гэсэн 7, 8 дугантай, 2000, 3000-аад ламтай, Жанжин Чойр нэртэй байсан. Шивээ уулын энгэрт байсан юм. Хойд энгэрт нь Баян уул гэсэн уул, зүүнтээ Норов уул гээд тахилгатай уул байсан.

Шивээ уулын энгэр дээр

Шижир алтан ганжиртай

Өглөө бүрий цогчэнтэй

Өдрийн дөрвөн солхоовтой гэж хэлдэг байсан юм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хийдийг хэзээ байгуулагдсаныг нь сайн мэдэхгүй байна. Чойр бол гол дацан хийд нь байсан. Авга гэдэг нь тарнийн дацан байсан. Ловон лам нь их том лам байсан. Ловон лам нь хувилгаан лам байсан юм. Баруун Чойрын тэргүүн лам нь Хувилгаан лам байсан юм. Мөн манай хийдэд эмийн тухай ном боловсруулдаг лам байсан.

Би Чойрт хурж байсан. Манай зиндаанд 30 гаран ламтай байсан. Зиндааны жорвоныг Ишсовд гэдэг байсан. Би дом тавьсан. 8, 9 зиндаа байсан. 8,9 жил сурна.

Манай хийд Чойрыг л голлодог. Модон дуганууд байсан. Чойр дуган 3 давхар байсан, хамгийн дээд давхарт шүтээнээ зална. Цогчэн дуган цагаан өнгөтэй, Авга, Жүд дацан улаан өнгөтэй байсан. Хийдэд суварга цөөхөн байсан. Номын бар байсан. Голдуу Чойрын ном төвдөөр барлаж байсан.

Цогчэндээ нийтийн гүрэм хурна. Цогчэнд өдөр тутам хурал хурна. 200, 300 лам багтах том дуган байсан. Манбаас маарамба болно. Цагаан сарын хурлыг олуулаа Цогчэнд хурна. Лам бүгд хурна. Манайд цам гардаг байсан. Хавар, зун, намарт лав 3, 4 удаа гарна даа. Майдар эргэхэд цам гарна. Хавар намрын цамаар хүмүүс их ирнэ. Ганжуур хүрээгээ тойрч эргэнэ. Ганжуураа тэврээд ч явна. Үүрээд ч явна. Хайлан хурдаг байсан. 40, 50 лам хайланд суудаг байсан. Хайлан 45 хоног үргэлжилнэ. Зарим газар хайлангийн тусгай дуган гэж байсан. Манайд байгаагүй. Нүгнээ сахидаг байсан. Хийсэн муу нүглийг л тайлах зорилгоор сахидаг байсан. Гавжийн дамжаа жилд 2 удаа барина. Хавар намар хоёр барина. Дамжаа барихад дацангуудын лам нар байна. Нэг удаад хоёр ч юмуу зургаа ч юм уу хүн байна. Манайх Чойроороо алдартай, чойрын 8-9 зиндаа байсан. Нэг зиндаанд 30-40 лам байж болно.

Жанжин Чойрт Зүүн Чойр гэж байсан. Хоёр Чойр маань хоорондоо нэлээд зайтай, 30-40 км байгаа байхаа. Хоёр Чойр харилцаа холбоотой. Хүрээний Дашчоймбэл дацантай харилцаатай байсан. Лам нар нь Төвд рүү явж сурч байсан. Нэг их олонгүй тусгай лам нар явж байсан.

Долоон жастай байсан. Дацан тус бүр жастай байсан. Чойр, Цогчэн, Жүд, Дүйнхор, Манба, Ламрин, Ёга гэсэн жастай байсан. Жасын малыг хариуцдаг ард байсан. Хонь цөөнтэй, адуу, үхэр зөндөө олон байсан.

Лам хуврагууд нь хүрээнд суудаг байсан. Лам нарын гэр хашаа нь баруун хүрээ зүүн хүрээг тойроод байрладаг. Лам нар гэрт, байшинд аль алинд нь амьдардаг байсан. Лам нараас бусад айлууд хүрээнээс холгүй байдаг байсан. Баруун хүрээ нь аймаглаж амьдардаг байсан. Тэр баруун хүрээ нь дотроо баруун хүрээ зүүн хүрээ гэж хуваагддаг. Хийдэд лүйжинч, зоч нар байсан. Лүйжингийн тусгай дуган байгаагүй. Хандмаа нар байгаагүй. Лам нар өдөр тутам хурлаа хурна. Зуны улиралд хөдөө гарна. Хийдийн ойролцоо худалдаа наймааны газар байгаагүй.

Миний багш нар гэж олон хүмүүс байсан. Нэлээд их эрдэм номтой лам нар байсан. Би одоо 80-аад настай, хийдэд 20 гаран жил болсон. Хийдийг хотоос нураасан, бурхан тахилыг нь устгасан. Одоо бол Ганданд суугаад 10-аад жил болж байна. Би цэрэгт 5 жил явсан. Тэгээд л хотод ирсэн.

Манай хийд дахин сэргээгдээгүй.